



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/506

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Улсын Их Хурлын 2009 оны 64 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 105 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймагт Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/-ээс Монголын жижиг дунд үйлдвэрийн салбарыг дэмжих төслийн хүрээнд “Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймаг, төслийн хамтын ажиллагааг сайжруулах, төслийг үр дүнтэй зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Л.Билэгдэмбэрэл

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Б.Туулайтулга

- Жаргалант сумын Засаг даргын орлогч

Д.Эрдэнэдорж

- Хүнс, хөдөө аж ахуйн газрын хэлтсийн дарга

Б.Ганзориг

- Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Ховд дахь салбар танхимын дарга

Н.Чимэгсүрэн

- Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Ховд дахь салбар танхимын менежер

Ш.Батжаргал

- “Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал

Н.Сумхүү

- Жаргалант сумын Магсаржав багийн Засаг дарга

- Ховд аймаг дахь Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслийн зохицуулагч

Нарийн бичгийн

дарга: Ц.Лувсанлхамо

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

2. Төслийг орон нутагт үр дүнтэй зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллан, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

